

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НУТГААС ОЛДСОН ХАДНЫ ЗОСОН ЗУРГИЙН ШИНЭ ДУРСГАЛ

Г.АНХСАНАА

*БХЯ, Монгол Цэргийн Музей
e-mail: g.anhaa@gmail.com*

Түлхүүр үгс: Зосон зураг, чагтан тамга, бэлгэдэл, зан үйл

ТОВЧ АГУУЛГА: *Тус өгүүлэлд Өмнөговь аймгийн нутгаас хайж илрүүлсэн хадны зосон зурагт дүрслэгдсэн чагтан тэмдгүүдийн утга агуулгыг хөндлөө. Чагтан тэмдгийг эртний хүмүүс шүтлэг биширэлтэй холбоотой зан үйл гүйцэтгэдэг газартаа онгод тэнгэрээ дуудан түүнийгээ буулгах тэмдэг болгон тавьдаг байсан хэмээн үзэв.*

Монголын эртний түүхийг судлах чухал сурвалж бол хадны сүг зураг юм. Хадны сүг зургийг судалсан эрдэмтэн судлаачид дүрсэлсэн арга барилаар нь хадны гадаргууг хонхойлгон цохисон, улаан зосоор зурсан болон хар бэхээр зурсан зураг хэмээн ерөнхийлөн ангилан авч үздэг. Эдгээр зургууд нь чулуун зэвсгийн үеэс дундад эртний үе хүртэл түүхийн олон үеийн турш бүтээгдсэн бөгөөд тухайн үеийнхээ аж байдал болон оюун санааны тусгал болсоноороо онцлогтой юм.

Өмнөговь аймгийн Номгон сумын төвөөс зүүн хойш 30 км орчим зайд орших Өлзийтийн талын хойд захыг эмжин өргөргийн дагуу 10-аад км сунаан тогтсон хадархаг уулыг Их Өвгөн уул гэж нутгийнхан хүндлэн дууддаг аж. Энэ бүс нутаг нь Монгол орны физик газар зүйн мужлалын хувьд Говийн их мужын Умарт говийн ухаа, гүвээг талын тойрогт хамаарагдана (Монгол орны физик газар зүй, 1969: 384, 398). Их Өвгөн уулын амууд олон сайр болон салаалах бөгөөд тэдгээрийн хоорондох тэгш дэвсгүүд, сайруудын эргээр эрт үед холбогдох олон зуун археологийн дурсгалууд тохиолдоно.



Зураг 1. Их Өвгөн уулын агуй

Их Өвгөн уулын өмнөд биед байх улаан боржин хадан толгой Их Бага хоёр хэсгээс тогтох ба Их улаан толгойг нутгийнхан Улаан хайрхан хэмээн тахидаг байсан ажээ. Бага улаан толгойн энгэрт байх зүүн урагш (азимутын 120°) харсан

амтай агуйн хананд улаан зосоор үйлдсэн хадны зураг байгааг бид нээн илрүүлсэн юм (Өмнөговь аймгийн Номгон сумын ..., 2008).

Тус агуй нь далайн түвшнээс 1581 м-ийн өндөрт, хойд өргөрөгийн $42^{\circ} 53' 42.9''$, зүүн уртаргийн $105^{\circ} 28' 44.8''$ солбилцолд орших бөгөөд агуйн үүд 2,4 м өндөр, 1,7 м өргөнтэй байв. Үүднээс агуйн мухар хүртэл барагцаалбал 6,8 м урт, агуйн дотор 40° орчим налуугаар 3 үеэлсэн өгсүүр байдал нь мэдэгдэх бөгөөд дотроо зүүн хойш чиглэсэн ойролцоогоор 2,4 м урт салаа тогтоцтой байна (Зураг 1).


Агуйн зосон зургууд бүгд баруун талын хананд байх бөгөөд энд улаан зосоор зурсан нийт 5 дүрс мэдэгдэж байв (Зураг 2). Эдгээрийг үүдэн талаас нь эхлэн дугаарлан тодорхойлбол: 1 дэх дүрс агуйн өнөөгийн гэрэлт түвшнээс 1,6 м өндөрт байх бөгөөд нилээд хэсэг нь бүдгэрч арилан тодорхой мэдэгдэхээ больсон байна. 2 дахь дүрс болох 9 см өндөртэй чагтан тэмдгийг эхний дүрсээс хойш 5 см зайд зуржээ. Үүнээс хойш 1,3 м зайд гэрэлт түвшинээс 1,2 м өндөрт 3, 4 дэх чагтан



Зураг 2. Их Өвгөн уулын агуйн зосон зураг

тэмдгүүдийг хооронд нь ойролцоо зурж дүрсэлжээ. Хамгийн ард 5 дахь дүрс болох чагтан тэмдгийг 4 дэх тэмдгээс 15 см – т бусад дүрснүүдээс зайдуу зурсан байна (Зураг 3).

Өмнө нь манай улсын нутгаас ийм чагтан тэмдэг дүрсэлсэн зосон зургууд цөөнгүй илрэн олдож байжээ. Тухайлбал Өвөрхангай аймгийн Зүүн Баян улаан сумын Их цоорхойн агуй, Уянга сумын Шурангын улаан хад, Арвайхээр хотоос урагш орших Баглуур хад (Дорж, Новгородова, 1975: 27, Таб XIX. Рис.1), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Гэр чулуу, Архангай аймгийн Жаргалант сумын Улиастайн гол, Дулааны үзүүр, Тайхир чулуу (Санжмятав, 1993: 10-11), Төв аймгийн Зуун мод, Зоргол хайрхан, Хэнтий аймгийн Биндэр сумын Бичигт хад, Норовлин сумын Баян-Өлзийтийн өврийн хад (Энхбат нар, 2008: 72), Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мандал толгойн агуй (Цэрэндагва, 2004: 29. зураг 1), Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Саалтын агуй (Цэвээндорж, Цэрэндагва, 2005: 16, 24, зураг 1) зэрэг газруудаас олджээ. Мөн Буриад болон Якут, Амур мөрний сав орчмын нутгуудаас олдсон зосон зургийн дурсгалууд дотор чагтан тэмдэг тохиолддог мэдээ баримт бий (Окладников и др., 1969; Цыбиктаров, 2006: рис. 16).



Зураг 3. Их Өвгөн уулын агуйн зосон зураг. Гар зураг

хүрлийн үеийн сийлмэл зургийн төрх шинж, утга агуулгатай олон талаараа ижилсэж байгаа нь тэдгээрийг хүрлийн үед холбогдохыг давхар гэрчилж байна хэмээжээ (1995: 18). Харин археологч Д.Цэвээндорж ийм тэмдэгт зургийг хадны зосон зургийн дэд төрөлд хамруулан авч үзээд неолитын үед магадгүй түүнээс ч өмнө үүссэн байхыг үгүйсгээгүй байна (Цэвээндорж, 1999: 65-66). Түүнчлэн А.И.Мазин Амур мөрний эхэн, Дорнод Өвөрбайгалын бүс нутгийн неолит ба хүрлийн үеийн хадны зургуудыг хэв шинжээр нь ялгаатай хоёр төрөлд хувааж үзсэн байдаг ба тэдгээр нь ойн бүсийн “тайгын” сэдэвтэй зургууд, тал хээрийн бүсийн “талын” сэдэвтэй зургууд болно. А.И.Мазин ялган гаргаснаар тайгын зургуудад агнуурын ба цаа бугын аж ахуйн дүрслэл давамгайлдаг бол талын зургуудад цэгээр дүрсэлсэн хашлага, системтэй эгнээ үүсгэсэн цэгүүд, «X» маягийн буюу чагтан тэмдэг, шувуу зэргийг дүрсэлсэн байдаг аж. Мөн тэрбээр тайгын сэдэвтэй зургуудыг Ар Байгалын Глазковын соёлын үеэс гаралтай гээд харин талын сэдэвтэй зургуудын гарал үүсэл одоо хүртэл таавар хэвээр байгааг тэмдэглэжээ (Мазин, 1994: 82-85, 87,88).

Тиймээс, бидний санахад, чагтан тэмдэг неолитын үеийн уламжлалаар өвлөгдөн улам хөгжиж шинэ дүрсүүдээр баяжин хувьсаж дараа үеүүдэд ч дүрслэгдэн зурагдаж байсан байж болох талтай юм. Тэрчлэн, аливаа шүтлэг бишрэл, зан үйл нь өмнөх үеийн уламжлалаас улбаалан бүрэлдэн бий болдгийг судлаачид өгүүлсэн байдаг (Заика, Журавков, 2002: 43-45).

Манай орны нутгаас олдсон ийм тэмдэг дүрсэлсэн зургууд ихэвчлэн агуйн хананд байгааг судлаачид анзаарсан байдаг билээ. Түүнчлэн агуйн хананд зурсан чагтан тэмдэг ямар утга санааг илэрхийлж байна вэ? гэдэг асуулт судлаачдын дунд одоо ч мөн таамаг хэвээр байна. Зарим нэгэн судлаачид хүнийг тоймлон дүрсэлсэн дүрс хэмээн үздэг байхад зарим нь нарны бэлгэдэл хэмээн үзэх нь бий (Цэрэндагва, 2004: 31). Харин туухай (чагтан Г.А) тамгадын тухай Өвөр Монголын судлаачдын үзснээр Монголчуудын адуу малын тамганы зураг дахь чагт ба хас хэлбэртэй

тамганууд цөм эртний хүмүүсийн нарны сахиусны шүтлэгтэй шууд холбоотой. Энэхүү чагтан зургийн хэлбэр анхандаа зөвхөн нарны гэрэл дөрвөн тийш сацран гийгүүлсний гол болох дөрвөн зүгийг зааж байсан, сүүлээр нь гэрэлт цогцын тэмдэг болоод, мөн түүхийн урт удаан хугацаанд аяндаа дээд тэнгэрийг ноёрхсон хамгийн их сахиусны тэмдэг болжээ хэмээн тайлбарлажээ (᠑᠙᠙᠘, 2001: 404).

Ер нь судлаачид агуйг эрт цагаас эхлэн хүмүүс оромж сууц, агуулах, оршуулга, ан отох газар, эмчилгээ сувилгаа, шүтээний газар болгон ашиглаж ирснийг тэмдэглэжээ (Эрдэнэбат, 2001: 18). Бидний бодлоор дээрх зосон зураг дүрсэлсэн агуйнууд нь голчлон хүн амьдран суухаасаа илүүтэйгээр шүтлэг бишрэлтэй холбоотой зан үйл гүйцэтгэдэг байсан бололтой байдаг. Чагтан тэмдгийг улаан зосоор зурсан байгаа нь энэхүү зургийг ямар нэгэн зан үйлийн тэр дундаа сүсэг бишрэлийн холбогдолтой болохыг харуулж байна. Мөн неолитын үед зосыг оршуулгын зан үйл зэрэгт цусыг бэлгэдэн хэрэглэж байсан тохиолдол Дорнод Монголоос олдсон булшнаас илэрч байжээ (Дорж, 1969: 49-50).

Аливаа сүсэг бишрэлийн түвшинг тодорхойлохдоо сүсэг бишрэлийн ухамсар, зан байдлын нийлбэрээр авч үзэх нь зүйтэй хэмээн үздэг (Чимэг, 1987: 58). Тиймээс, чагтан тэмдгийн дүрслэлийн утга учир, бэлгэдлийн талаар Монголчуудын бэлэгдэл зүй, угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүнээс хайх шаардлага гарч байна. Ийм мэдээ баримтыг эрдэмтэн С. Дулам «Монгол бэлэгдэл зүй» хэмээх бүтээлдээ дурдсан нь бидний сонирхож буй сэдвийг тайлбарлах сэжиг болохоор байна. Энэ нь Монголчуудын чагтан тамгын үүсэл гарал, түүнийг бэлгэдэх ёс юм. Тэрбээр, “Монголчуудын чагтан буюу зарим нутагт туухай тамга (өвөрлөгчид тоонолжин, сараалжин гэдэг) хэмээдэг энэ дүрс тэмдэг нь галын үүсэл болон гал гаргах арга хэрэгсэлтэй холбоотой байх хэдэн боломж буй. Үүнээс анх түрүүн хоёр модыг хавиралдуулан үрэлтийн аргаар гал гаргасан эрт баларлагийн туршлага сургамж байж болох юм. Дан болон давхар туухай (чагтан Г.А) тамга нь гаргаж авсан галаа хэрхэн ашигладаг болсонтой холбоотой загалмай зуух сэдэн бүтээсэнтэй басхүү холбоотой байж болно” гэж үзсэн байна (2007: 29). Загалмай зуух бол дөрвөн тийшээ харсан 4 амтай учраас хаанаас ч салхитай байлаа гэсэн галыг хөгжөөн бадраадаг онцлогтой билээ.

Түүнчлэн буриад бөөгийн ес дэх юмуу даган чанарын ёслолын үеэр газарт 9 загалмай зуух ухаж, есөн тогоо тогоолон онгодод өргөх адуун шүүсийг болгодог билээ. Мөн Буриад бөөгийн чанар хийх, чандруу нэрэх ёслолд “үүр” модны доод ишинд газраас 1 тохой өндөрт хуруу хэрийн урт хусан модыг зорж, зосоор улайлган дөрвөн талд нь шигтгэдэг “эргүү 4 загалмай” (эрюү дүрбэн загалмай) хэмээгч тэмдэг нь онгод сахиусны буух газрын тэмдэг мэт болдог нь газарт загалмай зууханд гал түлж дохио өгдөг эртний ёс заншлын улбаа байж болох юм гэж өгүүлсэн байна (Дулам, 2007: 29). Мөн зарим судлаачид эх модны доор дөрвөн зүгт хусан шаантаг шааж зосоор будсаныг загалмай гэж нэрлэдэг хэмээн дурдсан байдаг (Бадма-Оюу, 2001:28).

Үүнтэй холбогдуулан Монгол нутаг дахь бөөгийн шашны үүсэл хөгжлийн түүхийг авч үзвэл угсаатны зүйч С.Бадамхатан бөөгийн шашинг “анхны хүй нэгдлийн нийгмийн эцгийн эрхт ёсны үед үүний өмнөх үеийн сүсэг бишрэл болох маги, тотем, фетишизмын үндсэн дээр буй болсон” (1962: 37) гэж үзээд хожим нь бас “... түүхэн нөхцөл шалтгаан бол анхны хүй нэгдлийн нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн үед” үүссэн хэмээн лавшруулан өгүүлжээ (Бадамхатан, 1965). Тэрчлэн, эрдэмтэн О.Пүрэв Монгол нутагт бөөгийн шашин үүсэн, хөгжиж ирсэн он цагийн үечлэлийг хийхдээ “эхийн эрхт овгийн байгууллын үед буюу 5000-7000 жилийн өмнөх үеэс үүссэн” хэмээн үүсэл хөгжлийг авч үзсэн байна (2006: 25-27). Энэхүү он цаг Монголын түүхийн үечлэлийн неолитын үетэй тохирч байгаа юм (Монгол улсын түүх, 2003: 85-108). Тиймээс дээрх чагтан тэмдгийг, бөөгийн шашин үүссэн үе буюу неолитын үеэс эхлэн эртний хүмүүс шүтлэг бишрэлтэй холбоотой зан үйл гүйцэтгэдэг газартаа (агуйдаа) онгод тэнгэрээ дуудан, түүнийгээ буух тэмдэг болгон тавьдаг байсан байна хэмээн үзэж болохоор байна. Мөн одоо ч сум тусч онох онийг чагтан буюу хэрээсээр тэмдэглэдгийг энд дурдууштай.

НОМ ЗҮЙ

- Бадма-Оюу Б., 2001. Буриад бөөгийн “чанар хийх” зан үйлийн тухайд. *Studia ethnologica*. Tom XIII. Fasc. 3. УБ., 2003. т.27-29
- Бадамхатан С., 1962. Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм. УБ.
- Бадамхатан С., 1965. Хөвсгөлийн дархад ястан. УБ.
- Бат-Очир, 2001. *ᠪᠣᠮᠣᠨᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠨᠤᠳᠭᠠᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠳᠤᠨ ᠵᠣᠰᠣᠨ ᠵᠤᠷᠭᠢᠨ ᠰᠢᠨᠢ* //
- Дорж Д., Дорнод Монголын неолитийн үеийн булш, сууц. ШУАМ. УБ., 1969. №3. т.34-52
- Дорж Д., Новгородова Э.А., 1975. Петроглифы Монголии. УБ.
- Дулам С., 2007. Монголын бэлэгдэл зүй. Гутгаар дэвтэр (Дүрсийн бэлэгдэл зүй, дохио зангааны бэлэгдэл зүй). УБ.
- Заика А.Л., Журавков С.П., 2002. О развитии мировоззрений народов нижней ангары в эпоху неолит и палеометалла (по материалам культовых комплексов). Северная Евразия в эпоху бронзы: пространств, время, культура. Барнаул. с. 43-45
- Мазин А.И. 1994. Древние святилища Приамурья. Новосибирск: Наука, Сибирь. издательская фирма
- Монгол орны Физик газар зүй., 1969. Редактор. Ш.Цэгмэд. УБ.
- Монгол улсын түүх., 2003. Тэргүүн боть. УБ.
- Окладников А.П., Запорожская В.Д., 1969. Петроглифы Забайкалья. Л.
- Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойн ашиглалтын талбайд археологийн хайгуул судалгаа хийсэн тайлан. 2008. МУИС-Археологи-Антропологийн тэнхим. УБ.МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн тэнхим
- Пүрэв О., 2006. Монголын бөөгийн шашин. УБ. Дөрөв дэх хэвлэл
- Санжмятав Т., 1993. Архангай аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгал. УБ.
- Санжмятав Т., 1995. Монголын хадны зураг. УБ.
- Цэвээндорж Д., 1999. Монголын эртний урлагийн түүх. УБ.
- Цэвээндорж Д., Цэрэндагва Я., 2005. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрээс олдсон хадны зургийн зарим дурсгалаас. *Studia archeologica*. Tom (III) XXIII. Fasc.2. УБ. т.16-32
- Цэрэндагва Я., 2004. Хадны зосон зургийн шинэ дурсгал. *Studia archeologica*. Tom (II) XXII. Fasc.4. УБ. т.29-33
- Цыбиктаров А.Д. 2006. Централная Азия на заре бронзового века. Улан-Удэ.
- Чимэг О., 1987. Сүсэг бишрэлийг судлах арга зүйн зарим асуудал. *Studia philosophiae et juris instituti*. Tom III. Fasc.8. УБ. т.57-59

Г.АНХСАНАА

Энхбат Г., Оюунбилэг З., Даваацэрэн Б., 2008. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. I Боть, Хэнтий аймаг. УБ.

Эрдэнэбат У., 2001. Монгол орны агуйн археологийн судалгааны учир холбогдол. *Studia museologica*. Tom I (VI) . Fasc.3. УБ. т. 18-24.

РЕЗЮМЕ

Г. АНХСАНАА

**О НОВОМ ПАМЯТНИКЕ НАСКАЛЬНОЙ ПИСАНИЦЫ ВЫПОЛНЕННОЙ
ОХРОЙ ИЗ УМНЕГОВЬ АЙМАКА**

В данной статье автором предпринимается попытка дать анализ семантики **Х** - образных знаков на наскальных поверхностях, как отдельных скал, так и внутренних поверхностей пещер и ниш. Знаки выполнены охрой красноватого цвета. Автор, опираясь на работы монгольских археологов и этнографов, приводит близкие аналоги, касающиеся семантики данного знака.